



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/127

Улаанбаатар хот

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Дотны туслагч” өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан 968,742.12 (есөн зуун жаран найман мянга долоон зуун дөчин хоёр төгрөг арван хоёр мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн, алдаатай бүртгэлийг залруулахыг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Дотны туслагч” өрхийн эрүүл мэндийн төв (Ч.Цэрэндолгор)-д зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Дотны туслагч” өрхийн эрүүл мэндийн төв (Ч.Цэрэндолгор)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА  В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 10/14 дугаар тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн "Дотны туслагч" өрхийн эрүүл мэндийн төв

Д/д	Хөрөнгийн нэр	Марк, дугаар, үзүүлэлт	Ашигласан жил	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр	
							Нэгж үнэ	Нийт үнэ			Шилжүүлэх данс	Бүртгэх данс
1	Шүдний үзүүлэн	Ягаан	11	хэвийн	ш	1	250,000	250,000.00	250,000.00	-		
2	Судас тодруулагч	osi	6	хэвийн	ш	1	350,000	350,000.00	284,374.74	65,625.26		
3	Пульсоксиметр	pulse	6	хэвийн	ш	2	75,000	150,000.00	121,875.00	28,125.00		
4	Хүүхдийн пульсоксиметр	pulse	6	хэвийн	ш	3	72,914.04	218,742.12	161,777.76	56,964.36		
	Дүн							968,742.12	818,027.50	150,714.62		